



**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2024 оны 09 сарын 10 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

┌ Засгийн газрын салбарын тэргүүний ┐
ажилтан хүндэт тэмдэг болон
Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал олгох
журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалтын 33, 41, 45 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал олгох журмын 2.1, 3.1 дэх хэсгүүдэд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

1.1. Журмын 2.1.3 дахь заалтад “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”;

1.2. Журмын 2.1.5 дахь заалтад “Эдийн засаг, хөгжлийн яамны Хүндэт дэвтэрт бичиж, дурсгалын гэрчилгээ олгох”;

1.3. Журмын 3.1.4 дэх заалтад “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр:

а. Шинжлэх ухааны салбарт 15-аас доошгүй жил, мэргэжлээрээ идэвх зүтгэл, үр бүтээлтэй, ажлын өндөр амжилт гаргаж ажилласан ажилтан, албан хаагч болон бусад;

б. Эрдэм шинжилгээний бүтээл нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, олны хүртээл болсон зэргээр шинжлэх ухааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан эрдэмтэн, судлаач;

в. Шинжлэх ухааны салбарын мэргэжлээр хүний нөөцийг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, 3 болон түүнээс дээш судлаачийн эрдмийн ажлыг удирдаж, докторын зэрэг хамгаалуулсан их дээд сургуулийн эрдэмтэн, багш, судлаач;

г. Шинэ бүтээл, оновчтой санаачилга гарган улс эх орны өмнө тулгамдсан асуудлыг шинжлэх ухаан, технологийн ололтод түшиглэн шийдсэн инженер, зохион бүтээгч, эрдэмтэн судлаач;

1.4. Журмын 3.1.5 дахь заалтад “Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухааны салбарт 25-аас доошгүй жил ажиллаж, салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан албан хаагч, иргэдийн алдар гавьяа,

240051

үлгэр дуурайллыг алдаршуулж, Эдийн засаг, хөгжлийн яамны Хүндэт дэвтэрт алдар нэрийг нь мөнхжүүлэн бичиж үлдээнэ. Хүндэт дэвтэрт бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээг олгоно.”

2. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал олгох журмын 2.1 дахь хэсгийн “2.1.3.” гэснийг “2.1.4.” гэж, 3.2 дахь хэсгийн “журмын 3.1.1-3.1.3-т” гэснийг, “журмын 3.1.1-3.1.5-т ” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал олгох журмын нэгэн адил үйлчилнэ.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг нэгжийн дарга нарт, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Т.Баясгалан)-т тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД

Л.ГАНТӨМӨР

